



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 40

Улаанбаатар хот

XL ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хурлыг 2020 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордон дахь “Нутгийн удирдлага”-ын танхимд 77.5 хувийн ирцтэй цахимаар хуралдуулав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын нөхцөл байдлын мэдээлэл;

*Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан,*

2. Нийслэлийн хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлсэн хугацаанд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээлэл;

*Нийслэлийн Засаг дарга бөгөөд
Улаанбаатар хотын захирагч,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазар,*

3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор нийслэлээс бусад аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай;

*Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
бригадын генерал Г.Ариунбуян,*

4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хилийн бүх боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг түр зогсоосон хугацааг сунгах тухай;

*Хил хамгаалах ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн,
бригадын генерал Ж.Бямбасүрэн,*

5. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, бригадын генерал Г.Ариунбуян нарт:

1.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор нийслэлээс бусад аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар сунгах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

Хоёр. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Гадаад харилцааны сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Энхтайван,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн нарт:

2.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хилийн бүх боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар түр зогсоох;

2.2. Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас, бараа материалыг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг тухай бүр Улсын онцгой комисст танилцуулж, холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжүүлж ажиллах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

Гурав. Зам, тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Гадаад харилцааны сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Энхтайван,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Ж.Бямбасүрэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Ж.Болд,

Гаалийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Асралт,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Т.Гантулга,

Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим,

Монголын автотээвэрчдийн нэгдсэн холбоо,

Сэлэнгэ аймгийн Онцгой комиссын дарга Ш.Оргил нарт:

3.1. ОХУ-ын Хиагт боомтод ирээд байгаа олон улсын ачаа тээврийн автомашины чирэгч, чиргүүлийг хилийн Алтанбулаг боомт дээр солилцож, туршилтын татан авалт хийх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран 2021 оны 1 дүгээр сарын 02-04-ний өдрүүдэд зохион байгуулах саналыг Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх;

Дөрөв. Улсын онцгой комиссын гишүүдэд:

4.1. Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах үйлсэд мэргэжлийн ур чадвар, идэвхи зүтгэл гарган, хүч хөдөлмөрөө дайчлан тасралтгүй 11 сар ажилласан салбар салбарын төлөөлөл нийт 40 албан хаагчид мөнгөн урамшуулал олгох;

Тав. Нийслэлийн Засаг дарга бөгөөд

Улаанбаатар хотын захирагч,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Сумъяабазарт:


5.1. Нийслэлийн хэмжээнд коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлж буй үйл ажиллагааг эрчимжүүлэх;

5.2. Нийслэлийн Онцгой комиссоос олгож буй QR код олголттой холбоотой асуудлаар хяналт шалгалтыг хийж, зарим албан тушаалтанд хариуцлага тооцож, Улсын онцгой комисст танилцуулах;

5.3. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 90,000 иргэнийг PCR-ийн шинжилгээнд хамруулах ажлыг эрчимжүүлж, 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн дотор дуусгах;

5.4. Нийслэлийн Баянзүрх дүүргээс бусад дүүргийн иргэдийг коронавируст халдвар /КОВИД-19/-ыг илрүүлэх тандалтын шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах;

ДАРГА



Я.СОДБААТАР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА



Т.МӨНХДОРЖ